

Тавантолгойн нүүрсний ордыг
ашиглах талаар

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2010 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаар Стратегийн ач холбогдол бүхий Тавантолгойн нүүрсний ордыг ашиглах үзэл баримтлалын талаар Засгийн газраас танилцуулсан баримт бичгийн төслүүдийг хэлэлцээд ШИЙДВЭРЛЭСЭН нь:

1. Монгол Улсын Засгийн газраас ордыг ашиглах үзэл баримтлалыг Улсын Их Хуралд танилцуулах баримт бичигт Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжийн заалт чиглэлийг тодруулан тусгаж, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны болон шинжээчдийн санал, дүгнэлтийг тухай бүр харгалзан хэлэлцэж байх,

2. Тавантолгойн стратегийн хөрөнгө оруулагчдыг сонгон шалгаруулах баримт бичиг, гэрээний төсөл болон холбогдох бусад баримт бичгийг монгол, англи хоёр хэлээр алдаа мадаггүй боловсруулах,

3. Өнгөрсөн хугацаанд болон цаашид Тавантолгойг сонирхсон гадаадын хөрөнгө оруулагчидтай хийсэн уулзалт, ярианы тэмдэглэл, саналыг Засгийн газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд танилцуулж, хувийн хэрэг үүсгэж, ажлын хэрэгцээнд ашиглаж байх,

4. Урьдчилсан сонгон шалгаруулалтын баримт бичиг боловсруулах, сонгон шалгаруулах, хэлэлцээ хийх ажлын хэсгийг тус тусад нь байгуулж ажиллуулах. Хэлэлцээ явуулахдаа мэргэжлийн зохих түвшинд хадгалж, улс төрийн албан тушаалтанг хэлэлцээрийн аль нэг талд оролцуулахгүй байх зарчмыг баримтлах.

5. Тавантолгойн уурхайн ашиглалт, дэд бүтэц барьж байгуулах асуудлыг “Өмнийн говь” төсөлтэй уялдуулан Улсын Их Хуралд оруулах.

